



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/276

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн 79 дүгээр
сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,400,000.0 /зургаан сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль /У.Дугармаа/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль /У.Дугармаа/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 06 өдрийн А/272 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтанд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
Тавилга, эд хогшил											
1	Урлаг танхимын сандал			2019	Сайн	ш	80	80,000.00	6,400,000.00	Эцэг эх	Хандив
Тавилга, эд хогшлын дүн							80		6,400,000.00		
Нийт хөрөнгийн дүн									6,400,000.00		